

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16¹.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”-ыг нэгдүгээр, Байгаль орчны мэдээллийн сангийн статистик мэдээллийн маягыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт, Усны сав газрын захиргаадын дарга нарт даалгаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Усны газар /З.Батбаяр/-т үүрэг болгосугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Байгаль орчны сайдын 2014 оны 86 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.БАТ-ЭРДЭНЭ

УЛСЫН УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ, ХӨТЛӨХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь улсын усны мэдээллийн сан /цаашид “усны мэдээллийн сан” гэх/-ийн эх мэдээ, үзүүлэлтийг тогтоож, санг бүрдүүлэх, хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Усны мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөхтэй холбогдсон үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Усны мэдээллийн сан нь байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл хэсэг байх бөгөөд усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн үнэн бүрдлийг хариуцна.

1.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь усны мэдээллийн санг арга зүйн удирдлагаар хангаж, бүрдүүлэлтэд хяналт тавих ба усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага түүнийг бүрдүүлэх, нэгтгэн боловсруулах, хөтлөх ажлыг эрхлэн гүйцэтгэж Улсын усны мэдээллийн санд хадгална.

1.4. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл хэсгийг үнэн мэдээллээр бүрдүүлнэ.

Хоёр. Бүрдүүлэх мэдээ, мэдээлэл

2.1. Улсын усны мэдээллийн сан нь 1/ Улсын, 2/ усны сав газрын, 3/ аймаг, нийслэлийн, 4/ сум, дүүргийн усны мэдээллийн сан гэсэн ангилалтай байна.

2.2. Улсын усны усны мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:

2.2.1. Гадаргын ус;

2.2.2. Газрын доорх ус;

2.2.3. Рашааны мэдээлэл;

2.2.3. Ус ашиглалтын мэдээлэл;

2.2.4. Ус бохирдуулагч, хаягдал усны чанарын мэдээлэл;

2.3.5. Усны сав газрын мэдээлэл;

2.3.6. Усны барилга байгууламжийн мэдээлэл;

2.3.7. Усны тухай бодлого, хууль тогтоомж, салбарын бүтэц зохион байгуулалт;

2.3.8. Усны судалгаа шинжилгээ, техник технологи, төсөл хөтөлбөр;

2.3. Гадаргын усны мэдээллийн сан нь дараах үзүүлэлт, мэдээллээс бүрдэнэ.

2.3.1. Гадаргын ус (гол мөрөн, горхи, булаг шанд, нуур, тойром, хөв, цөөрөм, баянбүрд, усан сан, намаг, мөстөл, мөсөн гол)-ны сүлжээ, дүрс зүйн мэдээлэл, морфометрийн үзүүлэлтүүд (байршил, талбай, ус хурах талбай, урт, өргөн, гүн, хэвгий, өндөршил зэрэг),

2.3.2. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн зааг, холбогдох мэдээлэл,

2.3.3. Гадаргын усны хяналт шинжилгээний сүлжээ (харуул, өртөө, тэдгээрийн байршил, тодорхойлолт), хяналт шинжилгээний хөтөлбөр;

2.3.4. Усны объектын усзүйн болон гидрохимийн үзүүлэлтүүд (нөөц, ашиглаж болох боломжит нөөц, горим, найрлага, чанар, тоо, байршил);

2.3.5. Ус судлал, мөстөл судлалын өртөө, харуулын хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын хүрээнд гарган авсан статистик мэдээ (дундаж, хамгийн их, хамгийн бага утга), зураг;

2.3.6. Гадаргын усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын хүрээнд гарган авсан статистик мэдээ (биологийн үзүүлэлтүүд, бохирдуулах бодисын дундаж, хамгийн их, бага агууламж, усны чанарын стандартаас давсан хувь, бохирдлын индекс);

2.3.7. Гадаргын усны тоо бүртгэлийн дүн мэдээ;

2.3.8. Усан тээврийн зөвшөөрөл бүхий газрын байршил, тээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөр, орлогын хэмжээ;

2.3.9. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээсэн тухай мэдээлэл;

2.4.10. Усны гамшигт үзэгдэл, учирсан хохирол, авсан арга хэмжээ, зарцуулсан хөрөнгийн мэдээлэл.

2.4. Газрын доорх усны мэдээллийн сан нь дараах үзүүлэлт, мэдээллээс бүрдэнэ:

3.4.1. Газрын доорх усны эрэл хайгуул, зураглал, судалгааны мэдээлэл, (талбайн гидрогеологийн судалгаа, зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн судалгааны тайлан);

2.4.2. Газрын доорх усны ордын мэдээлэл (байршил, талбайн хэмжээ, судлагдсан байдал, батлагдсан нөөц, ашиглах боломжит нөөц, найрлага чанар, ашиглалт);

2.4.3. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүс, тэжээгдлийн мужийн хилийн зааг, холбогдох мэдээлэл;

2.4.4. Уст цэгийн мэдээлэл (өрөмдмөл худаг, цооног, богино яндант худаг, энгийн уурхайн худаг, гар худаг – байршил, ундарга нөөц, уст давхарга болон суулгасан яндан, шүүрийн мэдээлэл, өрөмдөгч, нээсэн/хаасан огноо, зориулалт, усны химийн найрлага, чанар, ашиглагч/эзэмшигч);

2.4.5. Газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээ (хяналтын цэг, тэдгээрийн төрөл, байршил, тодорхойлолт, сүлжээний төрөл), хяналт шинжилгээний хөтөлбөр;

2.4.6. Газрын доорх усны горимын хяналт шинжилгээний дүн мэдээ;

2.4.7. Газрын доорх усны чанарын хяналт шинжилгээний дүн мэдээ;

2.4.8. Цэвдгийн үндсэн мэдээлэл, хяналт шинжилгээний дүн мэдээ;

2.4.9. Усны нөөцийг хамгаалах, ордыг нөхөн сэргээсэн тухай мэдээлэл;

2.4.10. Усны нөөцөд учруулсан хохирол, нөхөн төлбөр;

2.5. Рашааны мэдээллийн сан нь дараах үзүүлэлт, мэдээллээс бүрдэнэ:

2.5.1. Рашааны эрэл хайгуул (бальнеологийн судалгаа, нөөцийн судалгаа);

2.5.2. Рашааны орд, эмчилгээний шаврын ордын мэдээлэл (төрөл, байршил, талбайн хэмжээ, судлагдсан байдал, батлагдсан нөөц, ашиглах боломжит нөөц, химийн найрлага чанар, ашиглалтын талаарх мэдээлэл);

2.5.3. Рашааны эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн хилийн зааг (газарзүйн солбицол), холбогдох мэдээлэл;

2.5.4. Рашааны орд, ашиглалтын хэмжээ, ашиглалтад тавьсан хяналт шалгалтын дүн, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт, бусад мэдээллүүд;

2.5.5. Рашааныг хамгаалах, хомсдохоос сэргийлэх тухай мэдээлэл.

2.6. Ус ашиглалтын мэдээллийн сан нь дараах үзүүлэлт, мэдээллээс бүрдэнэ:

2.6.1. Ус ашиглалтын баланс, төрлөөр (Унд ахуй; Үйлдвэрлэл – хөдөө аж ахуй - мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, эрчим хүч, хүнд үйлдвэр; хөнгөн үйлвэр, хүнсний үйлдвэр; Барилгын салбар – барилга, зам засвар; Ногоон байгууламж; Үйлчилгээ – нийтийн, амьтан үржүүлэг, аялал, ахуйн үйлчилгээ);

2.6.2. Усны үнэ тариф;

2.6.3. Ус ашиглагчийн талаарх мэдээлэл (ашиглагч, байршил, усны объект, зориулалт, хэмжээ, горим, ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл) – ус ашиглалтын хэмжээ (>100; 50-100;<50).

2.7. Ус бохирдуулагч, хаягдал ус, усны чанарын мэдээллийн сан нь дараах үзүүлэлт, мэдээллээс бүрдэнэ:

2.7.1. Ус бохирдуулагчийн талаарх мэдээлэл (ашиглагч, байршил, усны объект, зориулалт, хэмжээ, горим, чанар, найрлага, хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл);

2.7.2. Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр, шатлан өсгөх хэлбэрээр оногдуулах нөхөн төлбөр;

2.7.3. Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохиурдуулагч бодисын хэмжээ;

2.7.4. Цэвэр болон бохир усны дүн шинжилгээ, дүгнэлтүүд.

2.8. Усны сав газрын мэдээлэл

2.8.1. Сав газрын хэмжээнд усны мэдээллийн дэд санг эрхлэн боловсруулж, хадгалах, хамгаалах, түгээх, үйлчлэх ажлыг зохион байгуулна.

2.9. Усны барилга байгууламжийн мэдээлэл

2.9.1. Услалтын системийн мэдээлэл (эзэмшигч, байршил, усны объект, зориулалт, толгойн барилга, боомт, гол болон дамжуулах сувгийн хийц, зураг төсөл бусад мэдээлэл);

2.9.2. Үерийн хамгаалалтын далан (эзэмшигч, байршил, далан сувгийн хийц, зохиомж, зураг төсөл бусад мэдээлэл);

2.9.2. Цэвэрлэх байгууламж (эзэмшигч, төрөл, цэвэрлэгээний арга, зураг төсөл бусад мэдээлэл);

Гурав. Усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх эрх бүхий байгууллагуудын оролцоо

3.1 Энэ журмын 2.1-д заасан ангиллын дагуу сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь сум, дүүргийн усны мэдээллийн санг, аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь аймаг, нийслэлийн усны мэдээллийн санг, усны сав газрын захиргаа нь сав газрын усны мэдээллийн санг бүрдүүлж, улсын усны мэдээллийн нэгдсэн санг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хадгалах, түгээх, зохион байгуулах;

3.2. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны бүхий л мэдээллийг агуулах чадамж бүхий мэдээллийн санг боловсронгуй болгож хөгжүүлэх;

3.3. Энэ журмын 2.3.3, 2.3.4, 2.3.5, 2.3.6, 2.4.8 дахь заалтуудын мэдээллийг бүрдүүлэхдээ тухайн салбарын судалгаа, шинжилгээ явуулах эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж мэдээллийн сангийн бүрдлийг баяжуулна;

3.4. Энэ журмын 2.4.10, 2.9.2. дахь заалтуудын мэдээллийг аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газраас гарган нэгтгэж мэдээллийн сангийн бүрдлийг баяжуулна.

Дөрөв. Усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх ажлыг зохион байгуулах,

4.1. Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой

мэдээллийг жил бүр батлагдсан маягтын дагуу гаргаж сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хамрагдах Усны сав газрын захиргаанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.2. Сав газрын усны мэдээллийн дэд сан хөтлөж боловсруулж байгаа мэдээллийг Улсын усны мэдээллийн нэгдсэн санд нэгтгэн төвлөрүүлнэ.

4.3. Аймаг, нийслэл дэх усны мэдээллийг Улсын усны мэдээллийн нэгдсэн санд нэгтгэн төвлөрүүлнэ.

4.4. Судалгаа, шинжилгээний байгууллагуудын мэдээллийг Улсын усны мэдээллийн нэгдсэн санд нэгтгэн төвлөрүүлнэ.

4.5. Улсын усны мэдээллийн нэгдсэн сан, энэ журмын 1.2 дахь заалт болон бусад журмаар баталсан мэдээллийн нууцад багтсан мэдээллийн аюулгүй байдлыг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

Тав. Усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөлтийн тайлагнах хугацаа

5.1. Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны нөөц ашиглалт, хаягдал усны мэдээллийг жил бүр батлагдсан маягтын дагуу гаргаж сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хамрагдах Усны сав газрын захиргаанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.2. Улсын усны архивын мэдээллийн сан бүрдүүлэх усны жил бүрийн тоо бүртгэлийн тайланг усны сав газрын захиргаад жил бүрийн 11 дугаар сарын 30-ны өдрийн дотор усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хэвлэмэл байдлаар болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.3. Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн санд байршуулах БОХ 2.1, БОХ 2.2 маягыг боловсруулахдаа усны сав газрын захиргаа нь аймаг, нийслэлийн байгаль орчны газрыг мэргэжил аргагүйгээр ханган дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор цахимаар болон маягтаар хүргүүлнэ.

Байгаль орчин, аялал жуулчлалын
Сайдын 2023 оны ... дүгээр сарын ... -ны өдрийн
А-... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Маягт А-01. БОХ 2.1

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

З-БОХ-2.1

УСНЫ НӨӨЦ, ХОМСДОЛ, ХАМГААЛЛЫН 2021 ОНЫЖИЛИЙН МЭДЭЭ

1.ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил	Нэр	Код
Аймаг, нийслэл	Сэлэнгэ	1 3
Сум, дүүрэг	Зүүнбүрэн	

1. Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэдээг дараа оны 2 дугаар сарын 01-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газарт цахимгаар болон маягтаар ирүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчны мэдээллийн төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

3. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээг хянаад 2 дугаар сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын усны асуудал хариуцсан нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын усны асуудал хариуцсан нэгж нь мэдээг хянаж, нэгтгээд 3 дугаар сарын 10-ны дотор статистик хариуцсан нэгжид цахимгаар болон маягтаар ирүүлнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимгаар болон маягтаар ирүүлнэ.

2. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	МД	Нөөцийн хэмжээ, мян.м3	Усны эх үүсвэрийн тоо	Хашиж, хамгаалалтад авсан	Сэргэсэн	Хатаж, ширгэсэн	Тусгай хамгаалалтад авсан усны урсгац бүрэлдэх эх газрын талбай, мян.га
А	Б	1	2	3	4	5	6
Нийт мөр1=мөр(2+9)	1		620	2	x	x	1
Гадаргын ус мөр2=мөр(3-8)	2		21				
Гол, мөрөн	3	x	3	x			x
Нуур, тойром	4	x		x			x
Булаг, шанд	5	x	13	1			
Рашаан	6	x	1	1			1
Усан сан (хөв, цөөрөм)	7	x	4	x			x
Газрын доорх ус	8		x	x	x	x	x
Худаг мөр9 ≥ мөр10	9	x	499	x	x	x	x
Инженерийн хийцтэй худаг	10	x	66	x	x	x	x
Энгийн уурхайн худаг	11	x	443	x	x	x	x

Мэдээ хянасан: ЗДТГ-ЫН ДАРГА

ТАМГА

Мэдээг гаргасан: БОАХМ-ийн Б.ГЭЭ ЭЛТҮЯА

2023 оны 01 -р сарын 19 -ны өдөр



Маягт А-02. БОХ 2.2

УС АШИГЛАЛТЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1.ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил	Нэр	Код	
Аймаг, нийслэл	Говьсүмбэр	4	2
Сум, дүүрэг	Баянтал	0	4

1. Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэдээг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газарт цахимаар болон маягтаар ирүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчны мэдээллийн төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

3. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээг хянаж, 2 дугаар сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын усны асуудал хариуцсан нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын усны асуудал хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 10-ны дотор статистик хариуцсан нэгжид цахимаар болон маягтаар ирүүлнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимаар болон маягтаар ирүүлнэ.

2.ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Гадаргын уснаас		Газрын доорх уснаас
				Рашааны нөөцөөс		
А	Б	В	1	2	3	4
Ашигласан усны нийт хэмжээ мөр1=мөр(2+3+21)	1	мян.м ³	144601.8			144601.8
Хүн амын унд, ахуйн хэрэглээнд ашигласан	2	мян.м ³	10631.8			10631.8
Үйлдвэрлэлд ашигласан мөр3=мөр(4+8+9+15+17)	3	мян.м ³	132172		х	132172
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд мөр4=мөр(5:7)	4	мян.м ³	129336		х	129336
Газар тариаланд	5	мян.м ³			х	
Мал аж ахуйд	6	мян.м ³	127600		х	127600
Бусад	7	мян.м ³	1736		х	1736
Уул уурхайд	8	мян.м ³			х	
Боловсруулах үйлдвэрлэлд мөр9=мөр(10:14)	9	мян.м ³	536		х	536
Хүнсний үйлдвэрлэлд	10	мян.м ³			х	
Архи, пиво, ундааны үйлдвэрлэлд	11	мян.м ³			х	
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд	12	мян.м ³	536		х	536
Барилгын материалын үйлдвэрлэлд	13	мян.м ³			х	
Бусад	14	мян.м ³			х	
Эрчим хүчний үйлдвэрлэлд мөр15=мөр16	15	мян.м ³	2300		х	2300
Усан цахилгаан станцад	16	мян.м ³			х	
Барилгын салбарт мөр17=мөр(18:20)	17	мян.м ³			х	
Барилга угсралтад	18	мян.м ³			х	
Төмөр зам болон авто замын барилга байгууламж барихад	19	мян.м ³			х	
Бусад	20	мян.м ³			х	
Үйлчилгээнд ашигласан мөр21=мөр(22+23)	21	мян.м ³	2068		х	2068
Төрийн байгууллага	22	мян.м ³	1740		х	1740
Аж ахуйн нэгж, байгууллага мөр23=мөр24	23	мян.м ³	328		х	328
Аялал жуулчлалын	24	мян.м ³			х	
Дахин ашигласан усны хэмжээ	25	мян.м ³			х	
Эргүүлэн ашигласан усны хэмжээ	26	мян.м ³			х	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	27	мян.төг				
Усны нөөц, чанарыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардал мөр28=мөр(29:34)	28	мян.төг		х	х	х
Улсын төсвөөс	29	мян.төг		х	х	х
Орон нутгийн төсвөөс	30	мян.төг		х	х	х
Зээл, тусламж	31	мян.төг		х	х	х
Хөгжлийн албан ёсны тусламж	32	мян.төг		х	х	х
Хувийн хэвшлээс	33	мян.төг		х	х	х
Бусад эх үүсвэрээс	34	мян.м ³		х	х	х

Мэдээ хянасан / Л.Отгонпүрэв /

ТАМГА

Мэдээ гаргасан / Г.Анхбаяр /

20... оны ...-р сарын ...-ны өдөр